*БАЯНХОНГОР АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР*

# САНХҮҮГИЙН АУДИТЫН ТАЙЛАН

Баянговь ЗДТГ-ын 2019 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

**Аудитын код:** БНА-2020/17/СТА-ТШЗ

| | |
|---|---|
| Цахим хуудас: www.audit.mn<br>Баянхонгор хот<br>2020 он | Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын газрын дарга бөгөөд Тэргүүлэх аудитор: Б.Мөнхбат<br>Утас: 99007576 Цахим хаяг: munkhbatb@audit.gov.mn<br>Аудитын менежер: А.Цээням<br>Утас: Утас: 88011833 Цахим хаяг: tseenyma@audit.gov.mn<br>Ахлах аудитор: Б.Азбаяр<br>Утас:99061429 Цахим хаяг: Azbayarb@audit.gov.mn |

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

005 ТӨРИЙН АУДИТЫН БАЙГУУЛЛАГА ЗӨРЧИЛГҮЙ САНАЛ ДҮГНЭЛТ

## Товчилсон үгийн жагсаалт

| | |
|---|---|
| УСНББОУС | Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт |
| АДБОУС | Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт |
| АОУС | Аудитын Олон Улсын Стандарт |



005 ТӨРИЙН АУДИТЫН БАЙГУУЛЛАГА
ЗӨРЧИЛГҮЙ
САНАЛ ДҮГНЭЛТ

## Агуулга

Аудитын гэрчилгээ ........ 3
Аудитын тайлан ........ 4
2.1. Оршил ........ 4
2.2. Аудит хийх үндэслэл, зорилго, талуудын хүлээх үүрэг, хариуцлага ........ 4
2.3. Аудитад мөрдсөн бодлого, журам, арга зүй, шалгуур үзүүлэлт ........ 4
2.4. Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүйн орчин ........ 5
2.5. Нягтлан бодох бүртгэлийн бодлого, санхүүгийн үйл ажиллагаа болон дотоод хяналттай холбоотой хүчин зүйлсийн үнэлгээ ........ 5
2.6. Төлөвлөлтийн шатанд тодорхойлсон эрсдэл, түүнийг үнэлсэн байдал ........ 5
2.7. Материаллаг байдлын суурь сонгосон үндэслэл, тайлбар ........ 5
2.8. Санхүүгийн тайлангийн үзүүлэлтүүд ........ 6
2.10. Төсвийн гүйцэтгэлийн талаарх тайлбар, тодруулга ........ 7
2.11. Аудитаар хэрэгжүүлсэн горим сорил, түүний үр дүн ........ 7
2.12. Дараагийн аудитаар авч үзэх буюу анхаарал татахуйц бусад чухал асуудал ........ 8
2.13. Шилэн дансны мэдээлэл ........ 8
2.14. Өмнөх аудитаар өгсөн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт ........ 8
2.15. Дүгнэлтийн хэлбэр, үндэслэл ........ 8
Менежментийн захидал ........ 9
1.1 Аудит хийгдсэн санхүүгийн байдлын тайлан ........ 10
4.2 Аудит хийгдсэн санхүүгийн үр дүнгийн тайлан ........ 11
4.3 Аудит хийгдсэн мөнгөн гүйлгээний тайлан ........ 12
4.4 Аудит хийгдсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан ........ 14
4.5 Аудит хийгдсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан ........ 14



005 ТӨРИЙН АУДИТЫН БАЙГУУЛЛАГА
ЗӨРЧИЛГҮЙ
САНАЛ ДҮГНЭЛТ

**БАЯНХОНГОР АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**
64101 Баянхонгор аймаг,
Баянхонгор сум, Номгон баг
Утас, факс 7044 2584
E-mail; bayankhongor@audit.gov.mn

2020.02.14 № 1/85

танай ____________ -ны №____________ -т

БАЯНГОВЬ СУМЫН ЗАСАГ
ДАРГЫН ТАМГЫН ГАЗРЫН ДАРГА
Д.ОТГОНЖАРГАЛ ТАНАА

Аудитын гэрчилгээ

Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1, 18 дугаар зүйлийн 18.2, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-т заасны дагуу Баянговь сумын ЗДТГ-ын 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд санхүүгийн тайлангийн аудит хийв.

**Зөрчилгүй санал дүгнэлт**

Баянговь сумын ЗДТГ-ын 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээ болон төсвийн гүйцэтгэлийн тайланг материаллаг зүйлсийн хувьд Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, УСНББОУС-д нийцүүлж, Сангийн сайдын баталсан бодлого, журам, зааврын дагуу үнэн, бодитой, шударга илэрхийлсэн тул зөрчилгүй санал дүгнэлт гаргаж байна.

**Санал дүгнэлтийн үндэслэл**

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагуудын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, стандарт болон Аудитын олон улсын стандартад нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Санхүүгийн тайлангийн аудитын журам, зааврын дагуу гүйцэтгэсэн. Эдгээр нь санхүүгийн тайлан материаллаг буруу илэрхийллээс ангид эсэх талаар үндэслэлтэй баталгаа олж авах зорилгоор аудитыг төлөвлөж, гүйцэтгэхийг шаарддаг.

Аудитаар Баянговь сумын ЗДТГ-ын 2019 оны жилийн эцсийн төсвийн гүйцэтгэл,санхүүгийн тайлан дахь үлдэгдэл, ажил гүйлгээний дүн хэмжээ болон илчлэл тодруулга, тус байгууллагад мөрдөж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлого, бүртгэлийн хөтлөлт, программ хангамж, дотоод хяналтын систем болон удирдлагын хийсэн томоохон тооцооллыг шалгаж, аудитын санал дүгнэлтийг дэмжих нотлох зүйлсийг хангалттай цуглуулсан.

D:\бичиг хэрэг 2020-Албан тоот А4\
0050?0042

Бидний хийсэн аудит тус санхүүгийн тайлан, тодруулгад санал дүгнэлт өгөх хангалттай, зохистой үндэслэлийг бүрдүүлсэн бөгөөд аудитын дүнд үндэслэсэн санал, зөвлөмжийг аудитын тайланд тусгасан болно.

**Үүрэг хариуцлага**

Төсвийн захирагч нь Төсвийн тухай хуулийн 26 дугаар зүйлийн 26.1-т заасны дагуу тайлант хугацааны санхүүгийн тайлан, тодруулгыг Нягтлан бодох бүртгэлийн болон Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт, түүнтэй нийцүүлэн Сангийн сайдын баталсан журам, зааврын дагуу бэлтгэж тайлагнах үүрэгтэй.

Аудитын дээд байгууллагуудын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, стандарт болон Аудитын олон улсын стандартын дагуу аудитын хийж, жилийн эцсийн төсвийн гүйцэтгэл, санхүүгийн тайланд санал дүгнэлт өгөх нь төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР Б.МӨНХБАТ

D:\бичиг хэрэг 2020-Албан тоот А4\

## Аудитын тайлан

### 2.1. Оршил

Баянговь сумын ЗДТГ-ын 2019 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын дүн, дүгнэлтийг ЗДТГ-ын дарга Д.Отгонжаргал танд танилцуулж байна.

Энэхүү тайланд үйлчлүүлэгчийн санхүү, нягтлан бодох бүртгэл, дотоод хяналтын системд хийсэн үнэлгээний тойм, аудитын явцад илрүүлсэн гол зүйлс, гаргасан шийдлүүд, анхаарал хандуулахуйц асуудал, залруулаагүй материаллаг болон материаллаг бус алдаа зөрчил, тодруулга зэрэг аудитын үр дүн, аудитын дүгнэлтийн хэлбэр, түүний үндэслэлийн талаар тус тус хураангуйлан тэмдэглэв.

Аудитын дүнд үндэслэсэн үйлчлүүлэгчийн нягтлан бодох бүртгэл, тайлагнал, дотоод хяналтын системийг боловсронгуй, болгох зөвлөмжүүдийг Менежментийн захидалд тусгасан болно.

### 2.2. Аудит хийх үндэслэл, зорилго, талуудын хүлээх үүрэг, хариуцлага

Бид Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1, 15.2, 18 дугаар зүйлийн 18.2, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Баянговь сумын ЗДТГ-ын 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болгосон санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Баянговь сумын ЗДТГ-ын 2019 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн гаргасан төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, заавар, журмын дагуу үнэн зөв, шударга илэрхийлэгдсэн эсэхэд дүгнэлт өгөх нь энэхүү аудитын зорилт байв.

Төсвийн шууд захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайлангаа Төсвийн тухай хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн баталсан төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, журмын дагуу үнэн зөв, бодитой бэлтгэх үүрэгтэй.

Харин тухайн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг дээрх хууль болон бодлого, журмын дагуу материаллаг алдаагүй, үнэн зөв, шударга илэрхийлсэн эсэхэд дүгнэлт өгөх нь Төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

Аудитыг 2020.02.04-аас 2020.02.06-ний хооронд гүйцэтгэж, аудитын тайланг 2020.02.27-ний өдөр эцэслэн баталгаажуулж, Төсвийн захирагчид хүргүүлэхээр төлөвлөн, Баянхонгор аймаг дахь төрийн аудитын газрын ахлах аудитор Б.Азбаяр хариуцаж хэрэгжүүлэв.

Баянговь сумын ЗДТГ нь 2019 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланг Баянхонгор аймаг дахь төрийн аудитын газар-т 2020.01.13-ний өдрийн № 03 дугаар бүхий албан бичгээр ирүүлсэн байна.

### 2.3. Аудитад мөрдсөн бодлого, журам, арга зүй, шалгуур үзүүлэлт

АДБОУС, АОУС, нийтээр хүлээн зөвшөөрсөн бусад зарчимд тулгуурласан Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Төрийн аудитын байгууллагаас санхүүгийн тайланд аудит хийх журам, төрийн аудитын байгууллагаас санхүүгийн тайлангийн аудитад баримтлах ерөнхий чиглэл, арга зүйг мөрдөн ажиллав.

Дээрх стандарт, зарчим, журамд нийцүүлж аудитын үе шатны ажлыг гүйцэтгэж, холбогдох ажлын баримт материалаар баталгаажуулсан болно.



005 ТӨРИЙН АУДИТЫН БАЙГУУЛЛАГА ЗӨРЧИЛГҮЙ САНАЛ ДҮГНЭЛТ

**2.4. Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүйн орчин**

Баянговь сумын ЗДТГ-ын үйл ажиллагааны эрхэм зорилго нь "Орчин үеийн дэвшилтэт технологийг ажил албандаа нэвтрүүлж өндөр боловсрол мэргэжилтэй чадварлаг төрийн албаны бүтцээр төрийн үйлчилгээг байгууллага иргэдэд түргэн шуурхай, хүртээмжтэй, чанартай хүргэх. гэсэн эрхэм зорилго оршино.

Баянговь сумын ЗДТГ-ын үйл ажиллагааны чиглэлийг дараах байдлаар тодорхойлжээ. Үүнд:

• Төр эдийн засаг нийгмийн бодлогыг удирдлагын үйл ажиллагаа Засаг даргын дэргэдэх дотоод аудитын хорооны хурлаар хяналт шалгалтын үр дүнг баталгаажуулж хэлэлцүүлэх.

• Харьяалах нутаг дэвсгэрийнхээ эдийн засаг, нийгмийн хөгжлийн стратегийн төлөвлөлт, хөтөлбөр, төсөл зохиох, зохицуулах, хяналт, шинжилгээ хийх, үнэлж дүгнэх, бодлогын удирдамжаар хангах, Хурал, Засаг дарга, доод шатны нутгийн захиргааны байгууллагыг шаардлагатай мэдээллээр хангах.

Тайлант хугацаанд байгууллагын санхүүгийн үйл ажиллагаанд мөрддөг хууль, тогтоомж, бодлого, журамд өөрчлөлт ороогүй байна.

**2.5. Нягтлан бодох бүртгэлийн бодлого, санхүүгийн үйл ажиллагаа болон дотоод хяналттай холбоотой хүчин зүйлсийн үнэлгээ**

Бид санхүүгийн тайланд материаллаг алдаа байхгүй гэдгийг нягтлах үүднээс үйлчлүүлэгчийн нягтлан бодох бүртгэлийн бодлого, санхүүгийн үйл ажиллагаа, дотоод хяналтыг шаардлагатай гэж үзсэн хэмжээгээр дахин хянасан болно.

Тус газрын одоо мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь Сангийн яамнаас хэрэгжүүлж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлого, холбогдох стандарт, хууль тогтоомжтой нийцсэн байна.

Баянговь сумын ЗДТГ санхүүгийн тайланг бэлтгэхдээ нягтлан бодох бүртгэлийн "Санхүүгийн тооцоолох групп" ХХК-ийн "Acolous"" программ хангамж ашиглаж байна.

Баянговь сумын ЗДТГ-ын дотоод хяналтын эрсдэлийг төлөвлөлтийн үе шатанд Дунд гэж үнэлсэн бөгөөд гүйцэтгэлийн шатанд дахин хянахад дотоод хяналт үр нөлөөтэй байна.

**2.6. Төлөвлөлтийн шатанд тодорхойлсон эрсдэл, түүнийг үнэлсэн байдал**

Аудитаар Баянговь сумын ЗДТГ-ын бэлтгэсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл нь материаллаг хэмжээний алдаатай илэрхийлэгдээгүй гэсэн үндэслэлтэй нотолгоо олж авахын тулд байгууллагын гадаад дотоод орчин, дотоод хяналтыг судлан, эрсдэлтэй асуудлыг илрүүлж, үнэллээ.

Аудитыг төлөвлөх үе шатанд эрсдэлийн үнэлгээний урьдчилсан горим хэрэгжүүлэн 35 эрсдэлтэй асуудал тодорхойлж, эрсдэлийн үнэлгээний дүнд үндэслэн 35 асуудалд нарийвчилсан горим сорил хэрэгжүүлэхээр төлөвлөж баталгаажуулсан болно.

**2.7. Материаллаг байдлын суурь сонгосон үндэслэл, тайлбар**

Аудитыг төлөвлөх болон гүйцэтгэх үе шатны материаллаг байдлыг АДБОУС 1320, АОУС 320-ын дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр 2019 оны



005 ТӨРИЙН АУДИТЫН БАЙГУУЛЛАГА ЗӨРЧИЛГҮЙ САНАЛ ДҮГНЭЛТ

жилийн эцсийн санхүүгийн тайлангийн нийт зардлыг сонгож, эрсдэлийн түвшинг “дунд” гэж үнэлэн материаллаг байдлын хувь хэмжээг 2 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн үе шатанд сонгосон суурь үзүүлэлтийн дүн 510035,9 мянган төгрөгөөс тооцон 10200,7 мянган төгрөгөөр материаллаг байдлыг тодорхойлж, баталгаажууллаа.

Гүйцэтгэлийн үе шатанд материаллаг байдлын түвшинг 10200,7 мянган төгрөгөөр тооцсон нь үр дүнгийн тайлангийн зардлыг суурь болгон сонгосонтой холбоотой болно.

### 2.8. Санхүүгийн тайлангийн үзүүлэлтүүд

Баянговь сумын ЗДТГ-ын 2019 оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 24929,8 мянган төгрөгөөр буюу 5,8 хувиар буурсан байна. Өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлт гарсан бараа материал, үндсэн хөрөнгийн данс байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

/мянган төгрөг/

| Үзүүлэлт | Эхний үлдэгдэл | Эцсийн үлдэгдэл | Өөрчлөлт |
|---|---|---|---|
| Б | 1 | 2 | 3=2-1 |
| Мөнгөн хөрөнгө | 0 | 0 | |
| Авлага | 6,967.9 | 1,818.8 | (5,149.1) |
| Урьдчилгаа | - | - | - |
| Бараа материал | 48,352.5 | 62,374.2 | 14,021.7 |
| Үндсэн хөрөнгө | 1,177,687.5 | 1,960,991.3 | 783,303.8 |
| Нийт хөрөнгө | 1,233,007.9 | 2,025,184.4 | 792,176.5 |
| Өр төлбөр | 95.0 | 6.0 | (89.0) |
| Засгийн газрын оролцоо /Эздийн өмч/ | 1,232,912.9 | 2,025,178.4 | 792,265.5 |
| Нийт өр төлбөр ба цэвэр хөрөнгө өмчийн дүн | 1,233,007.9 | 2,025,184.4 | 792,176.5 |

Авлага дансны үлдэгдэл 5149.1 мянган төгрөгөөр буурсан нь өмнөх оны аудитын залруулгаар барилгын зураг төсөв хийлгэх мөнгө төвлөрч 5.0 сая төгрөгийн авлага барагдсантай холбоотой байна.

Бараа материалын дансны үлдэгдэл 14021.7 мянган төгрөгөөр өссөн гол шалтгаан нь ОНХС-аас малжуулах төслөөр ухна хуц авч тус байгууллагын дансанд бүртгэгдсэнтэй холбоотой байна.

Үндсэн хөрөнгийн дансны үлдэгдэл 783303,8 мянга төгрөгөөр өссөн нь “Говийн сэргэлт сан”-гаас 703267,2 мянган төгрөгийн Цэнгэлдэх хүрээлэнгийн тохижилт, цэцэрлэгжүүлэлт усалгааны системийн бүтээн байгуулалтын ажлыг хийж үнэ төлбөргүй хүлээлгэн өгсөн, ОНХС-гийн хөрөнгөөр 94488.4 мянган төгрөгийн хөрөнгө оруулалт хийсэн зэрэг шалтгаанаар хөрөнгө нэмэгдсэн байна. Тайлан оны элэгдлийн зардал 129689,2 мянган төгрөг байна. Мөн тайлант онд 61798.3 мянган төгрөгийн хөрөнгө актлах шийдвэр гарч, 39656,2 мянган төгрөгийн Халуун усны барилга, Орон сууц зэрэг хөрөнгө худалдан борлуулсан байна.

Өр төлбөр дансны үлдэгдэл 89,0 мянган төгрөгөөр буурсан нь 2018 онд үүссэн ҮЭ-ийн өглөгийг бүрэн барагдуулснаас шалтгаалсан байна.

Засгийн газрын оролцоо дансны үлдэгдэл 2025178,4 мянган төгрөг болж 792265,5 мянган төгрөгөөр өссөн нь тайлан үеийн үр дүн байна.



005 ТӨРИЙН АУДИТЫН БАЙГУУЛЛАГА ЗӨРЧИЛГҮЙ САНАЛ ДҮГНЭЛТ

**2.10. Төсвийн гүйцэтгэлийн талаарх тайлбар, тодруулга**

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн шууд захирагч нь энэ хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

Монгол Улсын 2019 оны төсвийн тухай хуульд зааснаар Баянговь сумын ЗДТГ нь тайлант онд өөрийн орлого төлөвлөөгүй байна.

Тайлант онд нийт 317354,9 мянган төгрөгийн төлөвлөгөө батлагдсан бөгөөд гүйцэтгэлээр 308909,7 мянган төгрөгийн санхүүжилт олгож, өмнөх онд авлагаар туссан 5000.0 мянган төгрөгийг санхүүжилтээр тооцон нийт 308897,6 мянган төгрөгийн гүйцэтгэл гарч 2845.4 мянган төгрөгөөр санхүүжилт дутуу авсан нь хог хаягдлын хураамж дутуу төвлөрүүлснээс шалтгаалсан байна.

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр харуулсан мэдээллийг энэ тайлангийн 4.5-д харуулав.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 308897,6 мянган төгрөг буюу 97,3 хувьтай байгаагаас гол хэмнэгдсэн зардал нь БГАҮ-ний хөлс буюу хог хаягдал зайлуулах зардал 2845,2 мянган төгрөг дутуу гарсантай холбоотой байна.

**2.11. Аудитаар хэрэгжүүлсэн горим сорил, түүний үр дүн**

Аудитыг төлөвлөх үе шатанд тогтоосон 32 эрсдэл тодорхойлж нийт 32 горим сорил хэрэгжүүллээ.

Аудитаар нийт 905,2 мянган төгрөгийн алдаа, зөрчил илэрснээс 186,6 мянган төгрөгийн алдаанд залруулга хийж, 718,6 мянган төгрөгийн алдаа зөрчлийг арилгах, давтан гаргахгүй байх 1 зөвлөмж өглөө.

Залруулаагүй алдаа, зөрчилтэй асуудлыг ангилсан байдал

(Мянган төгрөгөөр)

| № | Шийдэл | Тоо | Дүн | Тайлбар |
|---|---|---|---|---|
| 1 | Зөвлөмж өгсөн | 1 | 148,0 | |
| 2 | Албан шаардлага | 2 | 792817,2 | |
| | Дүн | 3 | 792965,2 | |

Аудитаар дараах 718.6 мянган төгрөгийн залруулагдаагүй алдаа илэрсэнд зөвлөмж хүргүүллээ. Үүнд:

1. Тайлан онд Говийн сэргэлт сангаас 703267,2 мянган төгрөгийн Цэнгэлдэх хүрээлэнгийн тохижилт, цэцэрлэгжүүлэлт усалгааны системийн бүтээн байгуулалтын ажлыг хийж үнэ төлбөргүй хүлээлгэн өгсөн байхад нягтлан бодох бүртгэлд бүртгээгүй байсан нь завсрын аудитаар илрүүлж тайланд тусгах албан шаардлага өгөхөөр шийдвэрлэсэн.

Энэ нь нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 14.4-т заасан "Нягтлан бодох бүртгэлд дараах зүйлсийг заавал бүртгэнэ", 14.4.2-т заасан "бүх хөрөнгө, хөрөнгө оруулалт, авлага" гэсэн заалттай нийцэхгүй, "Үнэн зөв" батламж мэдэгдлийг хангахгүй байна.

<u>**Шийдвэрлэсэн нь:**</u> Албан шаардлага өгч жилийн эцсийн тайланд тусгуулах.



005 ТӨРИЙН АУДИТЫН БАЙГУУЛЛАГА ЗӨРЧИЛГҮЙ САНАЛ ДҮГНЭЛТ

2. Байгууллагын дансанд бүртгэлтэй тээврийн хэрэгслийн эзэмшигчийг шалгахад 34550.0 мянган төгрөгийн ковш трактор, 55000,0 мянган төгрөгийн Лексус-570 маркын автомашин нь байгууллагын эзэмшилд шилжиж ирээгүй байна.

Энэ нь Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.2 дахь "Төсвийн хөрөнгө оруулалтаар бий болсон хөрөнгө нь төрийн болон орон нутгийн өмч байна" гэсэн заалттай нийцэхгүй, "эрх ба үүрэг" батламж мэдэгдлийг хангахгүй байна.

**Шийдвэрлэсэн нь:** Албан шаардлага өгөх.

3. Цалингийн тооцооллыг давтан шалгахад НДШ-д 148.0 төгрөгийг цалингийн зардлаас гүйлгэн зарцуулсан байна..

Энэ нь Сангийн сайдын 2014 оны 55 дугаар тушаалаар баталсан "Төсвийн зарлагын эдийн засгийн ангиллыг ашиглах заавар" " гэсэн заалттай нийцэхгүй, "хэмжилт" батламж мэдэгдлийг хангахгүй байна.

**Шийдвэрлэсэн нь:** Зөвлөмж өгөх.

**2.12. Дараагийн аудитаар авч үзэх буюу анхаарал татахуйц бусад чухал асуудал**

Байхгүй.

**2.13. Шилэн дансны мэдээлэл**

| д/д | Хугацаа | Төрөл | Удаа | Хугацаанд байршуулсан | Хугацаа хоцроож байршуулсан | Байршуулаагүй |
|---|---|---|---|---|---|---|
| 1 | Бүтэн жил | 11 | 11 | 10 | 1 | 0 |
| 2 | Хагас жил | 4 | 4 | 4 | 0 | 0 |
| 3 | Улирал бүр | 1 | 4 | 4 | 0 | 0 |
| 4 | Сар бүр | 3 | 36 | 28 | 7 | 1 |
| 5 | Тухай бүр | 8 | 96 | 82 | 14 | 0 |
| 6 | Нийт | 27 | 151 | 128 | 22 | 1 |

**2.14. Өмнөх аудитаар өгсөн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт**

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар: Зөвлөмж өгөөгүй байна.

**2.15. Дүгнэлтийн хэлбэр, үндэслэл**

Бид 2019 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланд аудит хийж, баталгаажуулах ажлыг АДБОУС-ын дагуу, Монгол Улсын холбогдох хууль тогтоомжид нийцүүлэн гүйцэтгэсэн.

"Зөрчилгүй" дүгнэлт

Баянговь сумын ЗДТГ-ын 2019 оны жилийн эцсийн санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, өмчийн өөрчлөлт болон бусад илчлэл тодруулгыг холбогдох хууль, УСНББОУС-ын дагуу материаллаг байдлын хувьд үнэн зөв, бодитой илэрхийлсэн эсэхийг Аудитын гэрчилгээнд тодорхой дурдав.



005 ТӨРИЙН АУДИТЫН БАЙГУУЛЛАГА ЗӨРЧИЛГҮЙ САНАЛ ДҮГНЭЛТ

## Менежментийн захидал

Төрийн аудитын байгууллага санхүүгийн тайлангийн аудит бүрийн төгсгөлд аудитаар илрүүлсэн зүйлсийг нэгтгэсэн менежментийн захидлыг үйлчлүүлэгч, түүний удирдлагад зориулж бэлтгэдэг бөгөөд түүнд санхүү, нягтлан бодох бүртгэл, тайлагналын бодлого, үйл ажиллагаа, дотоод хяналтыг сайжруулах зөвлөмжийг тусгадаг.

Энэхүү менежментийн захидлын агуулга аудитын үр дүн, дүгнэлтээс урган гарсан болно. Санхүүгийн тайлан, бусад илчлэл тодруулгын талаар санал дүгнэлт гаргахад бидний бодлого, горим зориулагдсан.

Энэ нь нягтлан бодох бүртгэлийн бодлого, горимыг зөвхөн аудитыг үр нөлөөтэй гүйцэтгэхэд шаардагдах цар хүрээнд дахин хянасан бөгөөд оршиж буй бүх сул талыг гаргаж ирэх боломжгүй юм.

Тиймээс аудитын тайланд тусгасан зөвлөмж нь аудит хийх үеийн нөхцөл байдлын талаарх бидний үнэлэлт, дүгнэлтийг илэрхийлж байгаа болно.

Харин эдгээр зөвлөмжийг та бидний хамтын ажиллагааны байр сууринаас гаргасан бөгөөд аудитаар өгсөн зөвлөмжийг хүлээн авч, хэрэгжүүлэх нь танай үүрэг хариуцлага юм.

Менежментийн захидалд дурдсан цаашид санхүүгийн тайланд шууд бөгөөд материаллаг хэмжээгээр нөлөөлж болзошгүй тул анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлоор нь эрэмбэлэн үзүүлэв. Үүнд:

1. *Тайлант хугацаанд хэрэгжүүлэх ерөнхий чиглэл*

***1.1. <u>Илрүүлэлт:</u>***

Цалингийн тооцооллыг давтан шалгахад НДШ-д 148.0 төгрөгийг цалингийн зардлаас гүйлгэн зарцуулсан байна.

***1.2. <u>Эрсдэл:</u>***

Батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулаагүй

**1.3. *<u>Өгсөн зөвлөмж:</u>***

Зардлыг хуульд заасан хувь хэмжээг харгалзан үзэж бодитой төлөвлөн зардал гаргахдаа Сангийн сайдын 2014 оны 55 дугаар тушаалаар батлагдсан "Төсвийн зарлагын эдийн засгийн ангиллыг ашиглах заавар"-ыг мөрдөж ажиллах.

**1.4. <u>Байгууллагаас өгсөн хариу тайлбар:</u>** Зөвлөмжийг хэрэгжүүлж ажиллана.

Дээрх зөвлөмжийн биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2020 оны 6 дугаар сарын 01-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.



005 ТӨРИЙН АУДИТЫН БАЙГУУЛЛАГА
ЗӨРЧИЛГҮЙ
САНАЛ ДҮГНЭЛТ

## 1.1 Аудит хийгдсэн санхүүгийн байдлын тайлан

Тайлант хугацаа: 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/төгрөг/

| Дансны код | Балансын үзүүлэлт | Эхний үлдэгдэл | Эцсийн үлдэгдэл |
|---|---|---|---|
| **1** | **ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН** | **55,320,392.50** | **64,193,078.00** |
| **33** | **АВЛАГА** | 6,967,916.00 | 1,818,833.00 |
| 33100 | Ажиллагчидтай холбогдсон авлага | 167,916.00 | 00.00 |
| **335** | **Бусад авлага** | 6,800,000.00 | 1,818,833.00 |
| 3351 | Байгууллагаас авах авлага | 6,800,000.00 | 1,818,833.00 |
| **35** | **БАРАА МАТЕРИАЛ** | 48,352,476.50 | 62,374,245.00 |
| **351** | **Түүхий эд материал** | 2,500,000.00 | 2,500,000.00 |
| 35110 | Тусгай зориулалттай материал | 2,500,000.00 | 2,500,000.00 |
| **354** | **Хангамжийн материал** | 35,538,476.50 | 39,560,245.00 |
| 35410 | Бичиг хэргийн материал | 3,294,008.00 | 1,557,175.00 |
| 35420 | Аж ахуйн материал | 4,492,100.00 | 4,312,100.00 |
| 35440 | Түлш, шатах тослох материал | 02.50 | 00.00 |
| 35450 | Барилгын засварын материал | 400,000.00 | 00.00 |
| 35470 | Бусад хангамжийн материал | 27,352,366.00 | 33,690,970.00 |
| 35600 | Мал амьтад | 10,314,000.00 | 20,314,000.00 |
| **2** | **ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН** | **1,177,687,471.12** | **1,960,991,283.06** |
| **39** | **ҮНДСЭН ХӨРӨНГӨ** | 1,177,687,471.12 | 1,960,991,283.06 |
| **392** | **Биет хөрөнгө** | 1,152,463,637.77 | 1,936,033,283.06 |
| 39201 | Барилга, байгууламж, орон сууц | 929,331,413.56 | 1,617,565,421.34 |
| 39202 | Хуримтлагдсан элэгдэл | -205,958,217.58 | -270,905,745.34 |
| 39203 | Авто-тээврийн хэрэгсэл | 125,822,600.00 | 161,150,000.00 |
| 39204 | Хуримтлагдсан элэгдэл | -56,764,266.78 | -68,133,333.58 |
| 39205 | Машин тоног төхөөрөмж (компьютер) | 89,001,400.00 | 202,509,848.00 |
| 39206 | Хуримтлагдсан элэгдэл | -66,953,589.94 | -45,274,932.36 |
| 39207 | Тавилга, аж ахуйн эд хогшил | 56,752,682.00 | 53,683,190.00 |
| 39208 | Хуримтлагдсан элэгдэл | -26,430,207.34 | -23,309,130.32 |
| 39209 | Зам, гүүрийн байгууламж | 199,800,000.00 | 199,800,000.00 |
| 39210 | Хуримтлагдсан элэгдэл | -34,632,000.00 | -42,624,000.00 |
| 39214 | Бусад үндсэн хөрөнгө | 164,888,118.20 | 229,493,158.20 |
| 39215 | Хуримтлагдсан элэгдэл | -55,711,294.35 | -78,238,192.88 |
| 39216 | Дуусаагүй барилга, байгууламж | 33,000,000.00 | 00.00 |
| 39217 | Ном | 317,000.00 | 317,000.00 |
| **393** | **Биет бус хөрөнгө** | 25,223,833.35 | 24,958,000.00 |
| 39301 | Програм хангамж | 1,550,000.00 | 850,000.00 |
| 39302 | Хуримтлагдсан элэгдэл | -1,194,166.65 | -760,000.00 |
| 39303 | Бусад биет бус хөрөнгө | 24,868,000.00 | 24,868,000.00 |
| **3** | **НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II** | **1,233,007,863.62** | **2,025,184,361.06** |
| **4** | **НИЙТ ӨР ТӨЛБӨР** | **95,000.00** | **6,000.00** |
| **41** | **БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР** | 95,000.00 | 6,000.00 |
| **413** | **Өглөг** | 95,000.00 | 6,000.00 |
| **4136** | **Бусад өглөг** | 95,000.00 | 6,000.00 |
| 41361 | Байгууллагад төлөх өглөг | 00.00 | 6,000.00 |
| 41362 | Хувь хүмүүст төлөх өглөг | 95,000.00 | 00.00 |
| **5** | **ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН** | **1,232,912,863.62** | **2,025,178,361.06** |
| **51** | **Засгийн газрын хувь оролцоо** | 1,232,912,863.62 | 2,025,178,361.06 |
| 511 | Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан | 513,984,711.00 | 513,984,711.00 |
| 51101 | Өмч: - төрийн | 513,984,711.00 | 513,984,711.00 |
| **512** | **Хуримтлагдсан үр дүн** | 517,506,178.74 | 1,319,290,696.27 |
| 51210 | Өмнөх үеийн үр дүн | 517,506,178.74 | 527,025,198.83 |
| 51220 | Тайлант үеийн үр дүн | 00.00 | 792,265,497.44 |
| 51300 | Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү | 201,421,973.88 | 191,902,953.79 |
| **6** | **ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V** | **1,233,007,863.62** | **2,025,184,361.06** |



005 ТӨРИЙН АУДИТЫН БАЙГУУЛЛАГА ЗӨРЧИЛГҮЙ САНАЛ ДҮГНЭЛТ

## 4.2 Аудит хийгдсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

Тайлант хугацаа: 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/төгрөг/

| Дансны код | Үзүүлэлт | Өмнөх оны гүйцэтгэл | Тайлант оны гүйцэтгэл |
|---|---|---|---|
| **1** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)** | **434,238,768.05** | **1,302,301,402.00** |
| **12** | **ТАТВАРЫН БУС ОРЛОГО** | **89,127,630.00** | **983,892,717.00** |
| **120** | **Нийтлэг татварын бус орлого** | 89,127,630.00 | 983,892,717.00 |
| 120004 | Төсөв байгууллагын өөрийн орлого | 89,127,630.00 | 983,892,717.00 |
| 1200042 | Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих | 3,600.00 | 00.00 |
| 1200045 | Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого | 89,124,030.00 | 983,892,717.00 |
| **13** | **ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО** | **345,111,138.05** | **318,408,685.00** |
| **1310** | **Улсын төвлөрсөн төсвөөс** | 7,500,000.00 | 00.00 |
| 131005 | Хөрөнгийн санхүүжилт | 7,500,000.00 | 00.00 |
| **1311** | **Нэмэлт санхүүжилтийн орлого** | 9,900,738.05 | 5,200,000.00 |
| 131104 | Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө | 9,900,738.05 | 5,200,000.00 |
| **1320** | **Орон нутгийн төсвөөс санхүүжих** | 315,710,400.00 | 308,909,701.00 |
| 132001 | Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/ | 315,710,400.00 | 308,909,701.00 |
| **1330** | **Төсвийн захирагчдаас** | 12,000,000.00 | 00.00 |
| 133003 | Хөрөнгийн | 12,000,000.00 | 00.00 |
| **1340** | **Нийгмийн даатгалын сангийн төсвөөс санхүүжих** | 00.00 | 4,298,984.00 |
| 134001 | Нийгмийн даатгалын сангаас санхүүжих | 00.00 | 4,298,984.00 |
| **2** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН** | **415,791,419.68** | **456,687,475.49** |
| **21** | **УРСГАЛ ЗАРДАЛ** | **415,791,419.68** | **456,687,475.49** |
| **210** | **БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ** | 371,082,086.66 | 438,116,425.49 |
| **2101** | **Цалин хөлс болон нэмэгдэл урамшил** | 168,107,360.00 | 184,756,389.00 |
| 210101 | Үндсэн цалин | 168,107,360.00 | 184,756,389.00 |
| **2102** | **Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл** | 20,412,660.57 | 23,327,161.00 |
| 210201 | Тэтгэврийн даатгал | 20,412,660.57 | 16,813,518.00 |
| 210202 | Тэтгэмжийн даатгал | 00.00 | 1,545,662.00 |
| 210203 | ҮОМШӨ-ний даатгал | 00.00 | 873,601.00 |
| 210204 | Ажилгүйдлийн даатгал | 00.00 | 287,122.00 |
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | 00.00 | 3,807,258.00 |
| **2103** | **Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал** | 11,525,879.50 | 12,371,597.50 |
| 210301 | Гэрэл, цахилгаан | 1,808,290.00 | 3,108,281.00 |
| 210302 | Түлш, халаалт | 9,717,589.50 | 9,263,316.50 |
| **2104** | **Хангамж, бараа материалын зардал** | 36,856,540.00 | 54,237,330.00 |
| 210401 | Бичиг хэрэг | 7,083,040.00 | 4,715,000.00 |
| 210402 | Тээвэр, шатахуун | 16,797,100.00 | 22,972,501.00 |
| 210403 | Шуудан, холбоо, интернэтийн төлбөр | 1,021,200.00 | 943,300.00 |
| 210406 | Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс | 11,955,200.00 | 25,606,529.00 |
| **2106** | **Эд хогшил, урсгал засварын зардал** | 4,630,900.00 | 5,921,500.00 |
| 210604 | Урсгал засвар | 4,630,900.00 | 5,921,500.00 |
| **2107** | **Томилолт, зочны зардал** | 5,093,500.00 | 9,789,200.00 |
| 210702 | Дотоод албан томилолт | 5,093,500.00 | 5,982,000.00 |
| 210703 | Зочин төлөөлөгч хүлээн авах | 00.00 | 3,807,200.00 |
| **2108** | **Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж** | 9,295,005.00 | 10,382,772.00 |
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | 7,729,755.00 | 9,062,772.00 |
| 210804 | Тээврийн хэрэгслийн татвар | 232,800.00 | 120,000.00 |
| 210805 | Тээврийн хэрэгслийн оношлогоо | 99,000.00 | 00.00 |
| 210806 | Мэдээлэл, технологийн үйлчилгээ | 1,233,450.00 | 1,200,000.00 |



005 ТӨРИЙН АУДИТЫН БАЙГУУЛЛАГА ЗӨРЧИЛГҮЙ САНАЛ ДҮГНЭЛТ

| | | | |
|---|---|---|---|
| **2109** | **Бараа үйлчилгээний бусад зардал** | 115,160,241.59 | 137,330,475.99 |
| 210901 | Бараа үйлчилгээний бусад зардал | 7,232,000.00 | 7,622,800.00 |
| 210903 | Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол | 107,928,241.59 | 129,707,675.99 |
| **213** | **УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ** | 44,709,333.02 | 18,571,050.00 |
| **2131** | **Засгийн газрын урсгал шилжүүлэг** | 3,000,000.00 | 12,900,000.00 |
| 213101 | Засгийн газрын дотоод шилжүүлэг | 3,000,000.00 | 12,900,000.00 |
| **2132** | **Бусад урсгал шилжүүлэг** | 2,277,480.00 | 5,658,984.00 |
| 213202 | Нийгмийн даатгалын тэтгэвэр, тэтгэмж | 00.00 | 4,298,984.00 |
| 213204 | Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал | 2,177,480.00 | 00.00 |
| 213209 | Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал | 100,000.00 | 1,360,000.00 |
| **2134** | **Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт** | 39,431,853.02 | 12,066.00 |
| 213403 | Төвлөрүүлэх шилжүүлэг | 39,431,853.02 | 12,066.00 |
| **3** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)** | **18,447,348.37** | **845,613,926.51** |
| **225** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН** | 148,660,246.36 | 53,348,429.07 |
| 225001 | Үндсэн хөрөнгө худалдсаны гарз | 58,702,838.33 | 53,348,429.07 |
| 225007 | Хөрөнгийн дахин үнэлгээний зардал | 89,957,408.03 | 00.00 |
| **4** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН (4)=(145-225)** | -148,660,246.36 | -53,348,429.07 |
| **5** | **НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)** | **-130,212,897.99** | **792,265,497.44** |

### 4.3 Аудит хийгдсэн мөнгөн гүйлгээний тайлан

Тайлант хугацаа: 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/төгрөг/

| Дансны код | Үзүүлэлт | Өмнөх оны гүйцэтгэл | Тайлант оны гүйцэтгэл |
|---|---|---|---|
| | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ** | | |
| **1** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)** | **325,614,738.05** | **323,408,685.00** |
| **12** | **ТАТВАРЫН БУС ОРЛОГО** | **3,600.00** | **00.00** |
| **120** | **Нийтлэг татварын бус орлого** | 3,600.00 | 00.00 |
| 120004 | **Төсөв байгууллагын өөрийн орлого** | 3,600.00 | 00.00 |
| 1200042 | Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих | 3,600.00 | 00.00 |
| **13** | **ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО** | **325,611,138.05** | **323,408,685.00** |
| **1310** | **Улсын төвлөрсөн төсвөөс** | 00.00 | 5,000,000.00 |
| 131001 | Урсгал үйл ажиллагааны санхүүжилт | 00.00 | 5,000,000.00 |
| **1311** | **Нэмэлт санхүүжилтийн орлого** | 9,900,738.05 | 5,200,000.00 |
| 131104 | Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө | 9,900,738.05 | 5,200,000.00 |
| **1320** | **Орон нутгийн төсвөөс санхүүжих** | 315,710,400.00 | 308,909,701.00 |
| 132001 | Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/ | 315,710,400.00 | 308,909,701.00 |
| **1340** | **Нийгмийн даатгалын сангийн төсвөөс санхүүжих** | 00.00 | 4,298,984.00 |
| 134001 | Нийгмийн даатгалын сангаас санхүүжих | 00.00 | 4,298,984.00 |
| **2** | **НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)** | **325,614,738.05** | **302,308,685.00** |
| **21** | **УРСГАЛ ЗАРДАЛ** | **325,614,738.05** | **302,308,685.00** |
| **210** | **БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ** | **263,720,405.03** | **283,597,635.00** |
| **2101** | **Цалин хөлс болон нэмэгдэл урамшил** | 167,755,032.00 | 184,808,934.00 |
| 210101 | Үндсэн цалин | 138,332,532.00 | 154,737,526.00 |
| 210102 | Нэмэгдэл | 29,422,500.00 | 28,012,781.00 |
| 210104 | Урамшуулал | 00.00 | 2,058,627.00 |
| **2102** | **Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл** | 20,669,989.03 | 23,195,700.00 |



005 ТӨРИЙН АУДИТЫН БАЙГУУЛЛАГА ЗӨРЧИЛГҮЙ САНАЛ ДҮГНЭЛТ

| | | | |
|---|---|---|---|
| 210201 | Тэтгэврийн даатгал | 20,263,735.03 | 15,700,200.00 |
| 210202 | Тэтгэмжийн даатгал | 00.00 | 1,873,900.00 |
| 210203 | ҮОМШӨ-ний даатгал | 00.00 | 1,499,100.00 |
| 210204 | Ажилгүйдлийн даатгал | 00.00 | 374,800.00 |
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | 406,254.00 | 3,747,700.00 |
| **2103** | **Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал** | 11,276,314.00 | 12,370,428.00 |
| 210301 | Гэрэл, цахилгаан | 1,808,290.00 | 3,107,114.00 |
| 210302 | Түлш, халаалт | 9,468,024.00 | 9,263,314.00 |
| **2104** | **Хангамж, бараа материалын зардал** | 20,219,740.00 | 24,563,400.00 |
| 210401 | Бичиг хэрэг | 4,633,040.00 | 2,727,900.00 |
| 210402 | Тээвэр, шатахуун | 14,565,500.00 | 20,272,200.00 |
| 210403 | Шуудан, холбоо, интернэтийн төлбөр | 1,021,200.00 | 943,300.00 |
| 210405 | Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал | 00.00 | 20,000.00 |
| 210406 | Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс | 00.00 | 600,000.00 |
| **2106** | **Эд хогшил, урсгал засварын зардал** | 15,794,800.00 | 2,344,700.00 |
| 210602 | Тавилга | 10,996,400.00 | 00.00 |
| 210604 | Урсгал засвар | 4,798,400.00 | 2,344,700.00 |
| **2107** | **Томилолт, зочны зардал** | 4,999,000.00 | 9,982,000.00 |
| 210702 | Дотоод албан томилолт | 4,999,000.00 | 5,982,000.00 |
| 210703 | Зочин төлөөлөгч хүлээн авах | 00.00 | 4,000,000.00 |
| **2108** | **Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж** | 14,812,230.00 | 17,239,133.00 |
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | 11,183,980.00 | 15,455,001.00 |
| 210803 | Даатгалын үйлчилгээ | 00.00 | 50,000.00 |
| 210804 | Тээврийн хэрэгслийн татвар | 22,500.00 | 70,000.00 |
| 210805 | Тээврийн хэрэгслийн оношлогоо | 49,000.00 | 00.00 |
| 210806 | Мэдээлэл, технологийн үйлчилгээ | 3,556,750.00 | 1,664,132.00 |
| **2109** | **Бараа үйлчилгээний бусад зардал** | 8,193,300.00 | 9,093,340.00 |
| 210901 | Бараа үйлчилгээний бусад зардал | 8,098,800.00 | 9,000,000.00 |
| 210902 | Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх | 94,500.00 | 93,340.00 |
| **213** | **УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ** | **61,894,333.02** | **18,711,050.00** |
| **2131** | **Засгийн газрын урсгал шилжүүлэг** | 20,185,000.00 | 12,900,000.00 |
| 213101 | Засгийн газрын дотоод шилжүүлэг | 20,185,000.00 | 12,900,000.00 |
| **2132** | **Бусад урсгал шилжүүлэг** | 2,277,480.00 | 5,798,984.00 |
| 213202 | Нийгмийн даатгалын тэтгэвэр, тэтгэмж | 00.00 | 4,298,984.00 |
| 213204 | Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал | 2,277,480.00 | 00.00 |
| 213209 | Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал | 00.00 | 1,500,000.00 |
| **2134** | **Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт** | 39,431,853.02 | 12,066.00 |
| 213403 | Төвлөрүүлэх шилжүүлэг | 39,431,853.02 | 12,066.00 |
| **3** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)** | **00.00** | **21,100,000.00** |
| **5** | **ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)** | **00.00** | **21,100,000.00** |
| **22** | **ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ** | **00.00** | **21,100,000.00** |
| **2200** | **Дотоод эх үүсвэрээр** | 00.00 | 21,100,000.00 |
| 225106 | Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал | 00.00 | 21,100,000.00 |
| **6** | **ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)** | **00.00** | **-21,100,000.00** |
| **8** | **НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)** | 00.00 | 00.00 |
| **9** | **Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл** | 00.00 | 00.00 |
| **10** | **Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл** | 00.00 | 00.00 |



005 ТӨРИЙН АУДИТЫН БАЙГУУЛЛАГА ЗӨРЧИЛГҮЙ САНАЛ ДҮГНЭЛТ

### 4.4 Аудит хийгдсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

Тайлант хугацаа: 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан
/төгрөг/

| Код | Үзүүлэлт | Засгийн газрын оруулсан капитал | Дахин үнэлгээний нөөц | Хуримтлагдсан дүн | Бусад | Засгийн газрын хувь оролцооний нийт дүн |
|---|---|---|---|---|---|---|
| D01 | **2018 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл** | **513,984,711.00** | **201,421,973.88** | **517,506,178.74** | **00.00** | 1,232,912,863.62 |
| D02 | Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт | 00.00 | 00.00 | 9,519,020.09 | 00.00 | 9,519,020.09 |
| D03 | **Дахин илэрхийлсэн үлдэгдэл** | **513,984,711.00** | **201,421,973.88** | **527,025,198.83** | **00.00** | 1,242,431,883.71 |
| D04 | Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт, бууралт | 00.00 | -9,519,020.09 | 00.00 | 00.00 | -9,519,020.09 |
| D05 | Үндсэн хөрөнгийн өсөлт, бууралт | 00.00 | 00.00 | 00.00 | 00.00 | 00.00 |
| D06 | Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз | 00.00 | 00.00 | 00.00 | 00.00 | 00.00 |
| D07 | Гадаад валютын хөрвүүлэлтийн зөрүү | 00.00 | 00.00 | 00.00 | 00.00 | 00.00 |
| D08 | Тайлант үеийн үр дүн | 00.00 | 00.00 | 792,265,497.44 | 00.00 | 792,265,497.44 |
| D09 | **2019 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл** | **513,984,711.00** | **191,902,953.79** | **1,319,290,696.27** | **00.00** | 2,025,178,361.06 |

### 4.5 Аудит хийгдсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

Тайлант хугацаа: 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан
/төгрөг/

| Эдийн засгийн ангилал | Үзүүлэлт | Өмнөх оны | | Тайлант оны | |
|---|---|---|---|---|---|
| | | Батлагдсан төлөвлөгөө | Гүйцэтгэл | Батлагдсан төлөвлөгөө | Гүйцэтгэл |
| **1** | **Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл** | | | | |
| **2** | **НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН** | 328,311,700.00 | 276,278,985.03 | 317,354,900.00 | 308,897,635.00 |
| **21** | **УРСГАЛ ЗАРДАЛ** | 328,311,700.00 | 276,278,985.03 | 317,354,900.00 | 308,897,635.00 |
| **210** | **БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ** | 256,906,600.00 | 253,816,505.03 | 291,854,900.00 | 288,397,635.00 |
| **2101** | **Цалин хөлс болон нэмэгдэл урамшил** | 170,144,400.00 | 167,755,032.00 | 185,353,200.00 | 184,808,934.00 |
| 210101 | Үндсэн цалин | 140,746,900.00 | 138,332,532.00 | 154,738,400.00 | 154,737,526.00 |
| 210102 | Нэмэгдэл | 29,397,500.00 | 29,422,500.00 | 30,614,800.00 | 28,012,781.00 |
| 210104 | Урамшуулал | 00.00 | 00.00 | 00.00 | 2,058,627.00 |
| **2102** | **Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл** | 20,784,500.00 | 20,669,989.03 | 23,195,700.00 | 23,195,700.00 |
| 210201 | Тэтгэврийн даатгал | 20,784,500.00 | 20,263,735.03 | 15,700,200.00 | 15,700,200.00 |
| 210202 | Тэтгэмжийн даатгал | 00.00 | 00.00 | 1,873,900.00 | 1,873,900.00 |
| 210203 | ҮОМШӨ-ний даатгал | 00.00 | 00.00 | 1,499,100.00 | 1,499,100.00 |
| 210204 | Ажилгүйдлийн даатгал | 00.00 | 00.00 | 374,800.00 | 374,800.00 |
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | 00.00 | 406,254.00 | 3,747,700.00 | 3,747,700.00 |
| **2103** | **Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал** | 11,362,900.00 | 11,276,314.00 | 12,389,900.00 | 12,370,428.00 |
| 210301 | Гэрэл, цахилгаан | 2,088,300.00 | 1,808,290.00 | 3,115,300.00 | 3,107,114.00 |
| 210302 | Түлш, халаалт | 9,274,600.00 | 9,468,024.00 | 9,274,600.00 | 9,263,314.00 |
| **2104** | **Хангамж, бараа материалын зардал** | 20,114,200.00 | 20,113,420.00 | 24,603,000.00 | 24,563,400.00 |
| 210401 | Бичиг хэрэг | 4,527,500.00 | 4,526,720.00 | 2,506,700.00 | 2,727,900.00 |
| 210402 | Тээвэр, шатахуун | 14,565,500.00 | 14,565,500.00 | 20,523,000.00 | 20,272,200.00 |
| 210403 | Шуудан, холбоо, интернэтийн төлбөр | 1,021,200.00 | 1,021,200.00 | 943,300.00 | 943,300.00 |



005 ТӨРИЙН АУДИТЫН БАЙГУУЛЛАГА ЗӨРЧИЛГҮЙ САНАЛ ДҮГНЭЛТ

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| 210405 | Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал | 00.00 | 00.00 | 30,000.00 | 20,000.00 |
| 210406 | Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс | 00.00 | 00.00 | 600,000.00 | 600,000.00 |
| **2106** | **Эд хогшил, урсгал засварын зардал** | 15,798,400.00 | 15,794,800.00 | 12,346,400.00 | 12,344,700.00 |
| 210602 | Тавилга | 11,000,000.00 | 10,996,400.00 | 10,000,000.00 | 10,000,000.00 |
| 210604 | Урсгал засвар | 4,798,400.00 | 4,798,400.00 | 2,346,400.00 | 2,344,700.00 |
| **2107** | **Томилолт, зочны зардал** | 5,476,500.00 | 4,999,000.00 | 9,982,300.00 | 9,982,000.00 |
| 210702 | Дотоод албан томилолт | 5,476,500.00 | 4,999,000.00 | 5,982,300.00 | 5,982,000.00 |
| 210703 | Зочин төлөөлөгч хүлээн авах | 00.00 | 00.00 | 4,000,000.00 | 4,000,000.00 |
| **2108** | **Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж** | 5,026,700.00 | 5,018,250.00 | 14,884,400.00 | 12,039,133.00 |
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | 1,390,200.00 | 1,390,000.00 | 13,100,200.00 | 10,255,001.00 |
| 210803 | Даатгалын үйлчилгээ | 00.00 | 00.00 | 50,000.00 | 50,000.00 |
| 210804 | Тээврийн хэрэгслийн татвар | 22,500.00 | 22,500.00 | 70,000.00 | 70,000.00 |
| 210805 | Тээврийн хэрэгслийн оношлогоо | 50,000.00 | 49,000.00 | 00.00 | 00.00 |
| 210806 | Мэдээлэл, технологийн үйлчилгээ | 3,564,000.00 | 3,556,750.00 | 1,664,200.00 | 1,664,132.00 |
| **2109** | **Бараа үйлчилгээний бусад зардал** | 8199000.00 | 8189700.00 | 9100000.00 | 9093340.00 |
| 210901 | Бараа үйлчилгээний бусад зардал | 8,099,000.00 | 8,095,200.00 | 9,000,000.00 | 9,000,000.00 |
| 210902 | Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх | 100,000.00 | 94,500.00 | 100,000.00 | 93,340.00 |
| **213** | **УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ** | 71405100.00 | 22462480.00 | 25500000.00 | 20500000.00 |
| **2131** | **Засгийн газрын урсгал шилжүүлэг** | 44,185,000.00 | 20,185,000.00 | 24,000,000.00 | 19,000,000.00 |
| 213101 | Засгийн газрын дотоод шилжүүлэг | 44,185,000.00 | 20,185,000.00 | 24,000,000.00 | 19,000,000.00 |
| **2132** | **Бусад урсгал шилжүүлэг** | 27,220,100.00 | 2,277,480.00 | 1,500,000.00 | 1,500,000.00 |
| 213204 | Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал | 2,359,100.00 | 2,277,480.00 | 00.00 | 00.00 |
| 213207 | Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж | 23,361,000.00 | 00.00 | 00.00 | 00.00 |
| 213209 | Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал | 1,500,000.00 | 00.00 | 1,500,000.00 | 1,500,000.00 |
| | **ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР** | **328,311,700.00** | **276,278,985.03** | **317,354,900.00** | **308,897,635.00** |
| **1320** | **ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ** | **328,311,700.00** | **276,278,985.03** | **316,754,900.00** | **308,897,635.00** |
| 132001 | Орон нутгийн төсвөөс | 328,311,700.00 | 276,278,985.03 | 316,754,900.00 | 308,897,635.00 |
| **120004** | **ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС** | 00.00 | 00.00 | 600,000.00 | 00.00 |
| 1200041 | Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих | 00.00 | 00.00 | 600,000.00 | 00.00 |
| **62** | **АЖИЛЛАГСДЫН ТОО** | 20.00 | 20.00 | 24.00 | 20.00 |
| 620001 | Удирдах ажилтан | 02.00 | 02.00 | 08.00 | 08.00 |
| 620002 | Гүйцэтгэх ажилтан | 12.00 | 12.00 | 07.00 | 07.00 |
| 620003 | Үйлчлэх ажилтан | 06.00 | 06.00 | 09.00 | 05.00 |
| **65** | **ОРОН ТООНЫ МЭДЭЭЛЭЛ** | **24.00** | **20.00** | **24.00** | **20.00** |
| 650001 | Төрийн захиргааны албан хаагч (ТЗ) | 08.00 | 08.00 | 08.00 | 08.00 |
| 650009 | Төрийн үйлчилгээний бусад албан хаагч (ТҮ) | 09.00 | 05.00 | 09.00 | 05.00 |
| 650011 | Улс төрийн албан хаагч (УТ) | 07.00 | 07.00 | 07.00 | 07.00 |

АУДИТЫН ТАЙЛАНГ

БЭЛТГЭСЭН:

АХЛАХ АУДИТОР: Б.АЗБАЯР 2020.02.14

АНХАН ШАТАНД ХЯНАСАН:

АУДИТЫН МЕНЕЖЕР: А.ЦЭЭНЯМ 2020.02.14

ХОЁР ДАХЬ ШАТАНД ХЯНАСАН:

ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР: Б.МӨНХБАТ 2020.02.14



005 ТӨРИЙН АУДИТЫН БАЙГУУЛЛАГА ЗӨРЧИЛГҮЙ САНАЛ ДҮГНЭЛТ